



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Судалгаа хийх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, 16.5.5, Нийслэлийн 2014 оны эдийн засаг, нийгмийн зорилтын 3.4.1.4, тус газрын дүрмийн 2.3, 4,5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн Налайх дүүргийн V, VI хорооны нутаг дэвсгэрт аялал жуулчлалын бүтээгдэхүүний нөөц тогтоох судалгааны ажлыг 2014 оны 05 дугаар сарын 05-ны дотор зохион байгуулахыг хот орчмын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн /Б.Ербахыт/-д, судалгаанд газрын мэргэжилтнүүдийг татан оролцуулахыг дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн /Э.Мөнхзул/-д тус тус даалгасугай.

2. Судалгааны ажлын удирдамж, чиглэлийг нэгдүгээр, судалгаанд шаардагдах төсвийн задаргааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Судалгаа хийхэд шаардагдах төсөв 631,000 /зургаан зуун гучин нэгэн мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 04 сарын 30 өдрийн
А/25 тоот тушаалын нэгдүгээд хавсралт



ХОТ ОРЧИМД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ ТОГТООХ, МЭДЭЭЛЛИЙН САН ҮҮСГЭХ СУДАЛГААНЫ АЖЛЫН УДИРДАМЖ

Зорилго:

Нийслэлийн Налайх дүүргийн V, VI хорооны нутаг дэвсгэрт аялал жуулчлалын бүтээгдэхүүний нөөц, маршрут тогтоох, мэдээллийн сан бүрдүүлэх, “Байгалийн аяллын жишиг суурин” төсөл боловсруулах

Хугацаа:

2014 оны 04-р сарын 30,31, 5-р сарын 01, 02–ны өдрүүдэд хийж гүйцэтгэнэ.

Хамрах хүрээ:

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүд дүүргийн V, VI хорооны нутаг дэвсгэрийг хэсэг болгон хувааж, хэсэг тус бүр дээр нэг баг ажиллана. Багууд тухайн хэсэгт судалгаа хийж, иргэд аялал жуулчлал эрхлэгчдээс мэдээлэл цуглуулна.

Хүрэх үр дүн:


Энэхүү судалгааг хийж гүйцэтгэснээр дараах үр дүнд хүрнэ.

- Судалгаанд тулгуурлан аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх боломж бий болно.
- Тухайн нутаг дэвсгэрт дотоодын аялагчдын сонирхлыг татах үзмэрүүдийг шинээр нээн илрүүлнэ.
- Аяллын шинэ чиглэлүүдийг тогтооно.
- “Байгалийн аялал жуулчлалын жишиг суурин болгон хөгжүүлэх төсөл”-ийг боловсруулах судалгаатай болно.

Судалгааны чиглэл:

№	Хамрах хүрээ, чиглэл	Багийн дугаар	Багийн гишүүд
1	Хорооны удирдлагатай уулзаж, 6,7-р сард хийх ажлуудыг төлөвлөх		Э.Баттулга Э.Мөнхзул
2	Тэрэлжийн төв хэсгээс Шугуй хүртэл, 6-р хороо	1-р баг	Д.Ганболд Д.Жаргалсайхан Б.Оюунзул
3	Тэрэлжийн гүүрээс Болор амралтын газар, Ар горхи, 6-р хороо	2-р баг	С.Туул Б.Халиун М.Баасандорж
4	Өвөр горхи, Мэлхий хад, Арьяабалын сүм, 6-р хороо	3-р баг	Ө.Ариунтунгалаг Б.Анар
5	Болор амралтын газраас Тэрэлжийн даваа, 6-р хороо	4-р баг	Б.Ербахыт Д.Монголхүү
6	Уу булангаас Цагаан жирээ хүртэл, 5-р хорооны нутаг дэвсгэрт	5-р баг	Н.Алтанзаяа Ш.Ундармаа
7	Цонжин болдог, Түмэн хишигтэн, 5-р хорооны нутаг дэвсгэрийн нутагт	6-р баг	Б.Жаргалан Г.Гансүвд

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 20.4-оны 01 сарын 3-өдрийн
тоот тушаалын хоёрдугаар хавсралт



ХОТ ОРЧИМД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ ТОГТООХ,
МЭДЭЭЛЛИЙН САН ҮҮСГЭХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Зам хоногийн мөнгө	16	18,000	288,000
2	Дунд оврын автобусны түрээсийн зардал	1	200,000	200,000
3	Шатахууны зардал	80 л	1790 <i>1600</i>	143,200
Нийт				631,200

ТӨСӨВ ЗОХИОСОН:

НАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Б.ЕРБАХЫТ

ХЯНАСАН:

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

П.АРИУНАА